

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ-/ИЙН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Хэлэлцсэн асуудал</b>	<b>Хуудасны дугаар</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны тоөч тэмдэглэл:</b>	1-9
<b>2.</b>	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	10-40
	1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, Ж.Ганбаатар нар 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	10-19
	2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	19-37
	3. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/	37-40

## **ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

**Хоёр. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын**

*төслийд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, Хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх О.Цолмон нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

*Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.12-т заасны дагуу гар өргөж санал хураалтыг явуулав.*

**Л.Энх-Амгалан:** 1.Төслийн 7 дугаар зүйлд нэмсэн 7.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	1
Бүгд:	14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	1
Бүгд:	14
92.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

3.Төслийн 12 дугаар зүйлд нэмсэн 12.1.9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	1
Бүгд:	14

92.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 25 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

### **“25 дугаар зүйл.Дүүргийн чиг үүрэг**

25.1.Дүүргийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

25.1.1.дүүргийн хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт, ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө;

25.1.2.дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хяналт;

25.1.3.дүүргийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;

25.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд татвар, хураамж, төлбөрийн хувь хэмжээ тогтоох асуудал;

25.1.5.дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт, тайлан, хяналт, бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;

25.1.6.худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл, хяналт;

25.1.7.нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;

25.1.8.дүүргийн цэцэрлэг, сургууль, эмнэлэг, соёлын төв, номын сан, биений тамир, спортын цогцолборын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

25.1.9.дүүрэг дэх авто зогсоолын арчилгаа;

25.1.10.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж, арчилгаа, хамгаалалт;

25.1.11.оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт;

25.1.12.дүүргийн гэрэлтүүлэг, арчлалт;

25.1.13.дүүргийн төвлөрсөн бус хүн амын унд, ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;

25.1.14.хог хаягдлын менежмент.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.6.Улсын хэмжээний бодлого дэвшиүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам, эвсэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй.

Тайлбар: Энэ хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулийн дараа өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 77 дугаар зүйл нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

**“77 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцаа**

77.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн, гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримталсан байна.

77.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай байгууллага хоорондын гэрээ байгуулж болох бөгөөд гэрээг байгуулахдаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар нар уг хэлэв.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	1
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар 77 дугаар зүйлийн гарчгийг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад хамтын ажиллагаа” гэж өөрчлөн найруулах гэсэн горимын санал гаргав.

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	1
Бүгд:	13

84.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар, Ц.Мөнх-Оргил, Н.Энхболд нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Үг асуудлыг 12 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Хоёр. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулна.

**Ж.Сүхбаатар:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Нямбаатар, Ц.Мөнх-Оргил, Ё.Баатарбилэг, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Н.Амарзаяа, Ж.Батзандан, Д.Ганболд нар 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхиын дэмжлэг авсан саналуудыг төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хувилбарт бэлтгэсэн хууль, тогтоолын төслүүдийг болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1.1 дэх заалтад заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим зүйл, заалтыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

Энэхүү чиглэлийн дагуу төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах, дүүргийн чиг үүргийг өөрчлөн найруулах, төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам, эвсэл, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй.

Энэ хэсгийг 2024 оны ээлжит сонгуулийн дараачаас эхлэн мөрдөнө гэж өөрчлөн найруулах талаар болон Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзэн төслийн 12 дугаар зүйлд 12.1.9 дэх заалт нэмэх гэснийг, 7 дугаар зүйлд 7.2 дахь хэсэг нэмэх гэснийг тус тус хасах, мөн төсөлд 6 дугаар бүлэг нэмж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцааны асуудлыг зохицуулах;

77.1.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримталсан байна.

77.2.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад улсын адил түвшний байгууллага, эсвэл олон улсын байгууллагатай байгууллага хооронд гэрээ байгуулж болох бөгөөд гэрээг байгуулахдаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байна гэсэн зүйлийг нэмэхээр Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгийн үед санал хураалгаж шийдвэрлүүлэв.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж хуулийн төслүүдийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Ж.Сүхбаатар гишүүнд баярлалаа.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж үг хэлэх, асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт хийнэ. 6 саналын томьёолол байгаа юм байна. Гишүүд тухайн томьёолол дээрээ бас үг хэлж болно.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 7 дугаар зүйлд нэмсэн 7.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд ээ. Гар өргөж санал хураалт хийж байгаа шүү.

14 гишүүн оролцож, 13 гишүүн зөвшөөрч энэ санал дэмжигдэж байна.

Ажлын хэсэг бас хүрэлцэж ирсэн байгаа. Ажлын хэсэг бас өмнөх хэлэлцүүлгийн үеэр байсан ажлын хэсэг.

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

14 гишүүн оролцож, 13 гишүүн зөвшөөрч энэ санал дэмжигдэж байна.

3.Төслийн 12 дугаар зүйлд нэмсэн 12.1.9 дэх заалтыг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

14 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдэж байна.

4.Төслийн 25 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

### **“25 дугаар зүйл.Дүүргийн чиг үүрэг**

25.1.Дүүргийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

25.1.1.дүүргийн хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт, ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө;

25.1.2.дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хяналт;

25.1.3.дүүргийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;

25.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд татвар, хураамж, төлбөрийн хувь хэмжээ тогтоох асуудал;

25.1.5.дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт, тайлан, хяналт, бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;

25.1.6.худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл, хяналт;

25.1.7.нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;

25.1.8.дүүргийн цэцэрлэг, сургууль, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

25.1.9.дүүрэг дэх авто зогсоолын арчилгаа;

25.1.10.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж, арчилгаа, хамгаалалт;

25.1.11.оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт;

25.1.12.дүүргийн гэрэлтүүлэг, арчлалт;

25.1.13.дүүргийн төвлөрсөн бус хүн амын унд, ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;

25.1.14.хог хаягдлын менежмент.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Ж.Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа.

Би ерөнхийд нь дэмжиж байгаа. Зүгээр яах вэ би сая бас Д.Ганзориг багштай санал солилцож байсан юм. Энэ хууль 2022 оны 01 сарын 01-нээс хэрэгжинэ. Дүүрэг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг гэж байгаа. Тийм ээ. 40 хувийг өөртөө төвлөрүүлэх боломжтой болж байгаа.

Тэгээд Сангийн яам, Татварын ерөнхий газруудад хандаад хэлэхэд аж ахуйн нэгжүүд нэг жаахан ингээд хөрөнгөжөөд ирэхээр нийслэлийн татвар луу аваад явчихдаг. Би одоо хэнд хандаж хэлэхэд байна. Ажлын хэсгийн ахлагч сонсож байгаа байх. Тийм ээ.

Ингээд нийслэл рүү аваад явчихдаг байхгүй юу. Аж ахуйн нэгж жаахан томрох юм бол. Тэгээд улс рүү аваад явчихдаг. Уг нь зарчим ямар байх ёстой вэ гэвэл энэ хаанаас тэр орлогоо төвлөрүүлж байна тэр газраа татвараа төлөх ёстой. Тэгэхээр энэ зарчмыг өөрчлөхгүй бол энэ аж ахуйн нэгжийн 40 хувийг орон нутагт нь үлдээнэ гэдэг чинь хийсвэр юм болно шүү. Сайн ойлгож байгаа байх гэж бодож байна.

Аж ахуйн нэгжүүдийг тодорхой орлоготой болгоод ирэхээр нь том татвар төлөгчдийг нийслэлд төвлөрүүлдэг байхгүй юу. Нийслэлийнх нь. Эсвэл улсын татварт авчихна. Үүнийгээ анхаарарай.

Дагалдах хуулиудад нь үүнийгээ. Эсвэл энэ одоо ямар зарчмаар ингэдэг юм. Би сайн мэдэхгүй байна. Үүнийгээ нэг анхаараад. Орон нутагт тэр хөгжих боломжийг нь олгож өгөөрэй гэсэн энэ саналыг хэлж байгаа юм.

Баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Ж.Ганбаатар гишүүн үг хэллээ. Санал хураалт. Гишүүд ээ.

14 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдэж байна.

5.Төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.6.Улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс

төрийн нам, эвсэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй.

Тайлбар: Энэ хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулийн дараа өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд ээ.

13 гишүүн оролцож, 11 гишүүн зөвшөөрч энэ санал дэмжигдэж байна.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 77 дугаар зүйл нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

**“77 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцаа**

77.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн, гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримталсан байна.

77.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай байгууллага хоорондын гэрээ байгуулж болох бөгөөд гэрээг байгуулахдаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байна.”

Санал гаргасан ажлын хэсэг. Их Хурлын дарга уг хэлье гэсэн үү?  
Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Энэ бусад асуудлуудыг нь нийлүүлээд ер нь хэлэхэд.

Одоо эцсийн хэлэлцүүлэг явж байна гээд. Чиглэл өгсөн. Тэгээд санал хурааж шийдсэн асуудлууд дээр Ц.Мөнх-Оргил гишүүний гаргасан нэг санал байгаа.

Тэрийг асуулт хариулт дээрээ. Тэгэхдээ энэ хоёрын дундуур нь уг нь эцсийн найруулга дээр анхаарах санал хураагаагүй асуудлууд бол орон нутагт өмчийн удирдлагын эрхийг өгөх. Одоо төрийн ба орон нутгийн өмч гэж нэрлэх нь муурыг хар юм уу, цагаан гэж нэрлэх нь гол биш. Хамгийн гол нь хулгана барьдаг байх хэрэгтэй гэж.

Орон нутгийн өмч гэж байгаа л бол тэр орон нутгийн өмчийн харилцаа гэдэг бол туйлын харилцаа. Өмчлөгчийн давуу эрх үүсгэж байх ёстой. Үүнийг энэ хуулиараа зааж өгөхгүй бол төрийн ба орон нутгийн өмчийн хуулиар Засгийн газарт тэр эрх мэдлийг шилжүүлэхгүй. Одоо нэг актлагдсан машинаа зарж борлуулах юм уу, аль эсвэл өөр байгууллагадаа шилжүүлье гэхэд Засгийн газрын хуралдаанаар ордог.

Тэгээд бүх аймгуудынх, сумуудынх ирээд байх учраас тэр болгон Засгийн газрын хуралдаанаар шийдэж чадахгүй. Жилдээ нэг удаа л Засгийн газрын хуралдаанаар оруулж шийдэж байдаг.

Тэгэхээр энэ чинь өөрөө корпорац дээр 58.1-ийг амьдруулахын тулд тэр орон нутаг чинь өмчөө өөрөө захиран зарцуулах, эргэлтэд оруулах, үр ашиггүйг нь хувьчлаад, үр ашигтайг нь эргэлтэд оруулаад татвар хураамжаа аваад. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа бол тэгж л хийгдсэн.

Тэгэхээр механикаас шууд цөөлж болохгүй. Яагаад гэвэл эрх мэдлийг нь өгөөгүй мөртлөө, энэ өмчийн удирдлагын эрх мэдлийг өдий болтол өгөөгүй мөртлөө.

Тэгээд энэ бүхнийг л цогцоор нь нэг харгалзаж үзнэ. Тодруулсан заалтаа л уг нь нэг заалт нэмж оруулмаар байгаа юм. Тэгээд ажлын хэсэг энэ өөрсдийнхөө яг хайрцгаас Д.Ганзориг дарга гарагч. Ж.Сүхбаатар дарга бол маш ойлгоод уян хатан ингээд зохицуулаад яваад байгаа юм. Ажлын хэсгийн даргын хувьд.

Дараагийнх нь нэг мөсөн хэлэхэд энэ гадаад харилцааны асуудал ч гэсэн бас зассан байгаа. Тэрийг тухайн үед нь бас ярья даа. Тэгээд ажлын хэсэг бол ер нь тэгээд хэлсэн чиглэлүүдийг нэг их анзаарч үзсэнгүй дээ.

Тэгээд энэ уг нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүрэн зүйн утгаар нь дээшлүүлэх асуудлыг 6.2 гэж нэг худлаа хуурсхийгээд л, унагаасан болгоод л.

Тэгээд хожим нь энэ орон нутгийн өмчтэй холбоотой гарах асуудал дээр ахиад шинэчлэх бол тэгээд л Д.Ганзориг доктор. Тэгээд орон нутгийн өмч гэж байхгүй болох гээд байгаа юм биш. Тэрийг юу ч гэж нэрлэнэ, төрийн өмч ч гэж нэрлэсэн хамаагүй тэр нь эрх мэдлийг нь өгөх л асуудал яриад байгаа шүү дээ.

Тэгтэл орон нутгийн өмч гэж нэрлэчхээд төрийн өмч эзэнгүйдэж байгаа мянган жишээ байна. Тэгсэн мөртлөө орон нутгийн өмч чинь ерөөсөө захиран зарцуулах, өмчлөх, эзэмших ямар ч эрхгүй явж байгаа өнөөдрийн практикиг л өөрчлөх ёстой заалтыг л тодруулж оруулах л шаардлагатай байсан юм.

Тэгээд яах вэ, түрүүн дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хяналт гээд ингээд бүгдийг нэгд.

Хяналт нь тэр дээрээ байж байх болно. Яг ашиглалт, захиран зарцуулалт төдийгүй эзэмших, ашиглах эрхийг л орон нутагт өгөх, бүрэн эрх асуудлыг үүгээр шийдэхгүй бол бусад процессын хуулиар хэцүү л болно доо.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга үг хэллээ.

Санал хураалт. Сүүлийнх. Тийм. 6 дугаар зарчмын зөрүүтэй санал.

13 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдэж байна.

Их Хурлын дарга. Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Энэ Ц.Мөнх-Оргил гишүүний хэлээд байсан санаа нь бол орон нутаг гадаад харилцааны бодлого хэрэгжүүлэхгүй. Гадаад харилцаа хэрэгжүүлэхгүй. Зүгээр гадаад харилцааны арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гадаад бодлогын үзэл баримталд нийцсэн, нэгдмэл байдлыг хангасан зарчмыг баримтална гэсэн агуулгаар.

Гадаад харилцааны “арга хэмжээ” гэдэг нэг тусдаа. Одоо тактикийн гэдэг юм уу. Стратеги нь бол улс баримтална гэдэг байдлаар.

Тэгэхээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж гадаад харилцаатай байх юм шиг гэж ойлгохгүй. Гадаад харилцааны арга хэмжээ байна гэж үзэж болно. Тэр айлчлал ч байдаг юм уу, арга хэмжээ ч байдаг юм уу. Арга хэмжээ гэдэг найруулгаар авчхаач ээ гэж би.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Найруулгыг гүйцээн боловсруулах юм байна шүү, Тийм. Эсхүл засаад санал хураачихъя.

Ц.Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ 6 дугаар санал хураалт дээр 77 дугаар зүйлийнхээ гарчгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцаа биш, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, гадаад харилцааны нэгжээс зохион байгуулах гадаад харилцааны арга хэмжээг гэсэн агуулгаар засаад.

Тэгээд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, гадаад харилцааны арга хэмжээнд оролцохдоо үндэсний аюулгүй байдал, гадаад үзэл баримтад нийцсэн гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримтална гэсэн тэр “арга хэмжээ” гэдэг утгаар нь явуулах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол энэ чинь нөгөө аймгийн гадаад харилцаа, нийслэлийн гадаад харилцаа гээд. Тийм.

**Л.Энх-Амгалан:** Яах вэ. Үүнийг тэгвэл өмнөх санал хураалтыг хүчингүй болгох ёстой биз дээ.

Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Үгүй ээ. Энэ чинь ийм шүү дээ. Одоо та хэд бас нэг ингэж болохгүй шүү дээ.

Гадаад харилцаа гэж байна шүү дээ. Энэ чинь одоо байгууллагын гадаад харилцаа гэж байдагтай адилхан энэ чинь нэгжийн гадаад

харилцаа гэж байлгүй яах вэ дээ. Энэ чинь улсын гадаад харилцаа бол ойлгомжтой. Нэгдмэл бодлого.

Одоо жишээлбэл Гадаад яамнаас би өнөөдөр авсан. Гадаад яаман дээр чинь журам байгаа шүү дээ. Энэ орон нутгийн гэрээг хянаж өгч байгаа. Тэгэхэд 258 гэрээг хянуулаагүй гэж дүгнэлт гаргасан байна лээ. 21-ийг л хянуулсан. 16 нь хамааралгүй. Тэгээд 295 гэрээ ингээд хийгдсэн. Тэрний чинь 258 нь хянагдаагүй.

Энэ чинь де-факто гадаад харилцаа байгаа шүү дээ. Гадаад хамтын ажиллагаа гэж байгаа. Тэгэхээр энэ гадаад харилцаа, хамтын ажиллагаа, арга хэмжээ гээд энэ чинь гадаад харилцааны хэлтэс гээд байж л таардаг шүү дээ. Гадаад хамтын ажиллагаа гээд. Бид гадаад хамтын ажиллагаа гэдгийг нь зүгээр хасчихсан юм. Бас нэг гадаад харилцаа. Гадагшаагаа нэгжийн гадаад харилцаа гэж.

Яах вэ гадаад хамтын ажиллагааг нь бол хасчихсан юм. Одоо бүр том нэртэй байгаад байвал тэр гадаад хамтын ажиллагаа нь илүү онож магадгүй байх л даа. Арга хэмжээ гэснээс.

Бодит амьдрал дээр энэ чинь угаасаа бүгд аймгууд гадаад харилцаа байна шүү дээ. Аль ч улс гадаад харилцаа байхаасаа гадна тэр дотор нь тэрэнд нь таарсан хувь хүмүүсийн өөрийнх нь гадаад харилцаа байж байна. Төрийн бус байгууллагуудын гадаад харилцаа байж байна.

Энэ чинь жишээлбэл энэ ойлголтоор төрийн бус байгууллагууд ч гадаад харилцаа байхгүй юм шиг ойлголт, тайлбар явж байна шүү дээ. Ямар арга хэмжээ биш. Тэр чинь бүгд л өөрийн гэсэн гадаад харилцаатай шүү дээ.

**Л.Энх-Амгалан:** Тэгэхээр яах вэ? Одоо дэгээр. Хамтын ажиллагаа, гадаад хамтын ажиллагаа. Тийм ээ.

Тэгвэл яах вэ Ж.Сүхбаатар гишүүн та горимын санал гаргаад.

Үүнийг тэгвэл энэ дээр найруулга хийе гэсэн горимын санал гаргачихъя тэгэх үү? Найруулчхаад орно л доо. Ж.Сүхбаатар гишүүн. Ажлын хэсгийн ахлагч горимын санал гаргана.

**Ж.Сүхбаатар:** Энэ гишүүдийн саналыг тусгаад 77 дугаар зүйлийн гарчгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад хамтын ажиллагаа гээд өөрчлөн найруулаад ингээд явчихъя. Найруулгаар. Тийм тийм.

Доторхыг нь тэгээд адилхан болгочихно л доо. Харилцаа гэдгийг нь. Тэгээд одоо та чиглэл өгчих.

**Л.Энх-Амгалан:** Тэгвэл саяын горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор.

**Ж.Сүхбаатар:** Бараггүй нь дээр.

**Л.Энх-Амгалан:** 13 гишүүн оролцож, 11 гишүүн зөвшөөрсөн.

Ингээд саяын ажлын хэсгийн ахлагчийн горимын санал дэмжигдсэн учраас Улсын Их Хурлын чуулганы эцсийн хэлэлцүүлэгт ороход найруулгыг гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна.

Ингээд зарчмын зөрүүтэй. Аан. Энэ чинь сүүлийн эцсийн хэлэлцүүлэг шүү дээ. Гуравны хоёроор шүү дээ. Тийм.

Эцсийн хэлэлцүүлэг дээр чинь Улсын Их Хурлын гишүүн зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Болохгүй шүү дээ. Эцсийн хэлэлцүүлэг дээр болох юм у?

**Ж.Батсуурь** гишүүн.

**Ж.Батсуурь:** Баярлалаа. Энэ ийм зүйл байгаа юм. Манай бүлэгт.

Энэ хуулийн төслийг анх өргөн барихад орон нутгийн сонгуулийн өмнө байсан.

**Ж.Ганбаатар** гишүүн ээ. Энд аягүй чухал юм ярих гээд байгаа юм. Тийм.

Тэгээд сонгуулийн өмнө байсан. Тэгээд сонгуулийн үр дүн гарчихсан. Одоо энэ зарим нэг хэсэг нь хүмүүс нь 2024 он хаана ч юм билээ гэж бодоод байгаа байхгүй юу.

Тэгэхлээр ингэж байгаа юм. Энэ хар даа. Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд одоо хүнийг хуралд санал болгож болно гэж. Тэгэхлээр дээд шатны Засаг дарга гэж байгаа байхгүй юу. Өмнө нь орчихсон.

Тэгэхлээр чинь зөвхөн Ерөнхий сайдын асуудал биш байна. Аймгийн Засаг дарга байна. Аймгийн Засаг дарга чинь сумын даргаа, сумын Засаг дарга чинь багийн дарга аа. Ингээд мянга гаруй хөдөлгөөн орно.

Тэгвэл энэ ингээд ганцхан өгүүлбэр юм шиг харагдаад байгаа боловч энд ахиад 56.7 дээр юу гээд ороод ирсэн бэ гэхээр дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд нэр дэвшигчийг томилохоос татгалзаж болно.

Яагаад татгалзах гэж байгаа юм. Хуулийн үндэслэл байхгүй. Өндөр гээд татгалзах гэж байгаа юм уу. Намхан гээд татгалзах гэж байгаа юм уу. Эрэгтэй гээд татгалзах гэж байгаа юм уу, эмэгтэй гээд татгалзах гэж байгаа юм уу. Зүгээр энэ чинь үзэмжийн асуудал болчжог байгаа байхгүй юу.

Тэгэхлээр ахиад үүний дараагийн асуудал болонгут 56.5-аар юу гээд оруулж ирж байна вэ гэхлээр энэ татгалзсан хүний дараа өөр хүнийг нэр дэвшигчийн гэж байгаа байхгүй юу.

Тэгэхлээр энэ хэлмэгдэл үүснэ. Шууд одоо ингээд багийн Засаг даргаас.

Д.Тогтохсүрэн дарга аа. Яг энэ ингээд юу болгоноор нь, заалт болгоноор нь харахад нэг их сүртэй биш юм шиг мөртлөө энэ гурван заалт чинь бие биенээ ингээд угсарсан. Угсрaad харах юм бол Монгол Улсын хэмжээнд төрийн тогтвортгуй байдал үүсэх, албан тушаалын наймаа үүсэх, хэлмэгдүүлэлт үүсэх, орон нутгийн эрх хэмжээг боомилох энэ хуулийн бүх үзэл санаа энэ гурван заалт дээр унаж байгаа.

Ж.Ганбаатар гишүүн ээ. Та хар даа.

Та бод л доо. Дээд шатны дарга доод шатны Засаг даргаа томилооос татгалзана гэж байна. Яагаад татгалзаж байгаа юм? Дээд боловсролгүй юм уу, дипломгүй юм уу, гэмт хэрэгт оролцож байсан юм уу. Огт юу ч байхгүй.

Тэгээд ингэж байгаа байхгүй юу. Буцаангут дараагийнх нь заалтаар өөр хүнийг нэр дэвшүүлнэ гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр чинь сайн хүн нэр дэвших юм бол. Би одоо. Энэ бол та хэд байна аа аймгийн дарга дээр хараад байгаа байхгүй юу. Биш. Гурван зуун хэдэн сум дээр будилаан гарна. Гурван зуун хэдэн сум чинь доошоогоо мянга гаруй баг дээр будилаан гарна.

Тэгнэ шүү дээ. Багийн даргыг хүрээд ирэнгүүт нь Засаг дарга нь би буцаах эрхтэй. Яагаад. Мэдэхгүй. Хууль дээр байгаа.

Сумын даргыг хүрээд ирэнгүүт аймгийн дарга нь буцаачихна. Яагаад би буцаж байгаа юм. Мэдэхгүй. Хууль дээр байж байгаа.

Аймгийн Засаг даргыг Ерөнхий сайд буцаачихна. Би яагаад буцаж байгаа юм. Мэдэхгүй. Хууль дээр байж байгаа.

Үгүй ээ, үгүй. Буцааж болно. Тэгвэл хуулийн үндэслэл байх ёстой шүү дээ. Хуулийн үндэслэл байхгүй байна шүү дээ. Энэ чинь зүгээр буцаана гэж байгаа байхгүй юу.

Тэгээд үүнийгээ баталгаажуулж байгаа юм шиг хар аа. 56.8 дээр байна шүү дээ. 56.5 дээр буцсан хүн дахиж нэр дэвшихгүй. Өөр хүн нэр дэвшинэ гэж байгаа байхгүй юу.

Тэгэхлээр чинь ямар нэгэн хүнийг нэр дэвшүүлчхээд дараагийн иргэдийн Хурал бол тэрийг унагахын төлөө зөндөө юм болно.

Ингээд аягүй учир утгагүй, хамгийн сайн боловсон хүчин танай нам манай нам гэхгүйгээр хэн ялахаас үл хамаараад 2024 онд эхлээд 21 аймаг, 9 дүүрэг дээр. Дараа нь 300 гаруй сум дээр. Дараа нь мянга гаруй багууд дээр энэ бол зүгээр л дураараа тоглолт болно. Нэгдүгээрт.

Нөгөөдөх нь. Л.Энх-Амгалан гишүүн ээ. Юу хэлэх юм уу? Энэ З заалт хоорондоо уялдаатай заалт.

Ж.Ганбаатар гишүүн ээ. Энэ аягүй чухал шүү.

Үгүй ээ. Нээрээ аймаар чухал шүү.

Нөгөөдөх нь. Тэр аль намаас үл хамаарна шүү. Одоо хүмүүс юу гэж хандаж байна вэ гэхлээр 2024 оноос эхлэх заалт юм чинь энэ ер нь хэзээ ч хамаатай юм. 2024 он нь хэзээ ч болоо билээ гэсэн байдлаар хандаж байгаа байхгүй юу. Тийм.

Би нөгөө нэг юугаа дараа нь болох юм уу?

**Л.Энх-Амгалан:** Тэг тэг.

**Ж.Батсуурь:** Баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Д.Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Ж.Батсуурь гишүүний яриад байгаа бол бас зарчмын том асуудал.

58 дугаар зүйл. Одоо бол 56 болсон байна.

Энэ дээр яах вэ гэхээр гурван асуудал байгаа юм. Ж.Батсуурь гишүүн. Манайхан их анхааралтай сонсоорой.

Нэгдүгээр асуудал нь тэр Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга санал болгохтой холбоотой заалт байгаа. Энэ бол яах вэ Үндсэн хууль зөрчөөгүй юм. Зүгээр санал болгож байгаа юм.

Шийдэх эрх нь Их Хуралд байгаа юм. Тэрийг хэн болж байна гэж. Ж.Батсуурь гишүүн ээ.

Хоёр дахь юм нь нөгөө буцаахтай холбоотой заалт Үндсэн хууль дээр Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга 1992 онд орсон Үндсэн хууль дээр л байгаа. Одоо ч байгаа. Нэг удаа буцааж болно гэдэг заалт нь.

Тэгээд Үндсэн хуулийн заалт өөрөө энэ учраас бид үүнийг ярьж байгаад л оруулсан заалт. Энэ заалтаар буцааж байсан зөндөө тохиолдлууд байгаа. Өмнө нь энэ чинь 30 жил хэрэгжсэн заалт байхгүй юу. Тийм. 30 жил хэрэгжсэн заалт.

Шалтгаан тавьдаггүй юм. Тэгээд л буцаачихдаг юм. Энэ нэг ийм тохиолдол байдаг юм.

Одоо харин бидний ярих ёстой нэг л асуудал байгаа юм. Өөр хүн дэвшүүлнэ гэдэг л жаахан асуудал үүсгэчхээд байгаа юм. Хуучин бол энэ

өөр хүн байгаагүй юм. Тэр хүнээ ч ирүүлж болно, өөр хүн ч ирүүлж болно. Одоо өөр хүн гэсэнд л Ж.Батсуурь яриад байгаа санаа нь тэр байгаа юм.

Тэрийг зүгээр Байнгын хороо нэг ярих уу, үгүй юу гэдэг асуудал л байгаа юм. Ганцхан “өөр хүн” гэдэг үгийг. Бусад нь би ярих шаардлагагүй асуудал байгаа юм. Ганцхан “өөр хүн” дээр бол нэг ярьж болох юм байна гэж.

Буцаах эрх нь өөрөө Үндсэн хуулиар тэр томилдог субъект байгаа байхгүй юу. Монгол Улс чинь өөрөө нэгдмэл улс. Тийм учраас энэ буцаах эрх бол. Харин 1992 оны Үндсэн хуулийн дараа гарсан нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиар хоёр удаа буцаадаг байсан юм. Гурав дахь удаагаа томилдог байсан юм. Бүр. Тийм. Тийм учраас тэр буцаахтай холбоотой зүйл ийм байгаад байгаа юм.

**Л.Энх-Амгалан:** Их Хурлын дарга. Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Энэ Их Хурлын чуулган дээр бас энэ асуудлыг нэг эргэж харах талаар бас ярьж чиглэл өгч байсан. Яасан л даа.

Энэ нэг ийм зэрэгцээ юм бол байж болмооргүй байгаа юм. Энэ хожим аягүй их сөрөг үр дагавар гаргаж болно.

Ер нь Үндсэн хуулийн зарчим бол төрийн удирдлагын босоо, нутгийн удирдлагын хэвтээ зарчмын огтолцол дээр энэ эрх ашиг хангагдах ёстой гээд. Ингээд Ерөнхий сайд батламжилдаг. Тэрийгээ зөвшөөрч болдог, буцаадаг энэ механизмуудаа хийчхээд. Хуралд яг зэрэгцэж нэр дэвшүүлдэг ийм субъект болохоор энэ аягүй том хагарлын зөрчлийн үүдийг нээгээд байж магадгүй.

Тийм учраас нэг талдаа гаргах нь зарчмын хувьд зөв юм байгаа юм. Яагаад ажлын хэсэг ингэж зэрэгцүүлсэн юм. Ийм юм онолын хувьд байж болохгүй шүү дээ.

**Л.Энх-Амгалан:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Энэ бол Их Хурлын даргын хэлж байгаа шиг ажлын хэсгийн асуудал биш.

Энэ бол тэгж ярих юм бол намын тэр удирдлага, тэр нам намынх нь улсуудынх нь хийсэн ажил шүү. Одоо бүр ингээд хэлчихье тэгвэл.

Энэ чинь манай ажлын хэсгийн улсууд үүнийг нь харин яаж зөвлөн томьёолох вэ гэж л суусан болохоос биш. Энэ томьёолол чинь бол орон нутгийн сонгуулийн өмнө өөрсдөө тийм юм бүлэг дээр яриад, тэгээд бүлгээс дэмжүүлээд, ингээд үүнийг оруулж ирсэн.

Харин манай ажлын хэсэг дээр ийм сонирхол гэдэг юм уу, ийм хүслээр хийгдсэн нэг ч хүний санал байхгүй. Үүнийг хэлэхээс арга алга. Юмыг бас үнэнээр нь хэлэхгүй бол.

Тэр дотор маргаан үүсэж байгаа юу гэвэл үүсэж байгаа шүү дээ. Тэрэндээ тулах юм бол Ардчилсан намын бүлгийнх ч үүнийг эсэргүүцэж байгаа. Манай намын гишүүд дотор ил биш ч гэсэн энэ одоо эргэлзэж байгаа гэсэн улсууд ч байна. Орон нутгаас ч үүнийг эсэргүүцэж байгаа хүмүүс байгаа. Ийм л юм байгаа наадах чинь. Тэрнээс биш бид л үүнийг чинь ухнадаад суугаад байгаа юм биш л дээ.

Тэгэхээр энэ дотор бол яах вэ зүгээр үүнийг бид хийхдээ байж болох хүрээнд нь тэр дээрээс томилгооны давуу байдлыг бий болгох бодлого бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үед ярьж ярьж байгаад чадаагүй.

Үндсэн хуулийнхаа хослуулах зарчмын огтлолцол гээд түрүүн Их Хурлын даргын хэлдэг огтлолцол дээр хийж болох хамгийн боломжит хувилбарыг маш олон талаас нь бодож хийсэн.

Энд сайн юм бий, муу юм бий. Тэр бол мэдээж тэр нам харгалзахгүй. Тэрүүний хэлээд байгаа шүүмжлэл дээр. Зарим үед энэ чинь оновчтой биш болно. Зарим үед оновчтой. Энэ чинь ингээд манайх шиг ийм улс алга байна л даа гол нь.

Хурлынх нь гүйцэтгэх байгууллага, Засгийн газрынх нь төлөөлөгч хоёр нь нэг хүн байдаг ийм тогтолцоо чинь одоо бараг байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ огтлолцуулна гэдгийн дотор чинь энэ балансалж. Бидний оруулсан хувилбар бол бас шүүмжлэлтэй тал байгаа ч гэсэн одоогийн хувилбараас бас муу биш. Одоогийн явж ирж байгаа одоогийн энэ тогтолцооноос бол. Бидний одоогийн юм бол ихэнх талаараа дээрдэж байгаа. Одоогийн явж ирсэн тогтолцоо нь бол.

Тэгэхдээ энэ бол тийм төгс болоод бүгдийг нь зохицуулчаж байгаа юм биш. Энэ улс төрийн адarmaатай харилцаанууд байгаа байхгүй юу. Зүгээр үүнийг цаашдаа зүгээр бидний хийсэн дүгнэлт юу юм бэ гэхээр Монголын нутгийн удирдлагын энэ хэлбэрийн асуудал дээр Үндсэн хууль дээр ингээд цоожилчхоод байгаа болохоос биш сонголттой хувилбартай баймаар юм байна лээ. Загварууд.

Зарим нь хурал нь давуу байж болдог. Зарим нь Засгийн газар нь дээрээсээ давуу байж болдог ч гэдэг юм уу. Ийм шаардлага. Жишээлбэл, байгалийн баялаг ихтэй аймаг, сумдад томилгооны давуу байдал үүсгэмээр байгаа юм. Хүмүүс чинь бараг шууд томилъё гээд байна шүү дээ.

Одоо бусдыг нь хэлэлтэй нь биш. Бусад газар нь хурал нь жаахан давуу байдал эдэлмээр байгаа юм. Энэ чинь нутгийн өрөө удирдах байгууллагын чинь юмыг бусад оронд манайх шиг ингэж Үндсэн хууль, ийм хуулиараа деталчилсан улс алга л даа.

Зүгээр боломж олгох үүднээс нь хуульчилсан улсууд бол байна. Ийм хувилбараар. Одоо Англид жишээлбэл юу гэдэг юм. Мер комиссын тогтолцоо гэдэг дээр чинь жишээлбэл турван хувилбартай байснаа нэг

хувилбараа хасаад хоёр хувилбарыг тэр орон нутагт сонгож болдог ч гэдэг юу. Холбооны улс л даа гэхдээ.

Тэгэхээр энэ нутгийн өрөө удирдлагын асуудал чинь өөрөө тийм яг энэ дээрээс хүчлэн тогтооход хэцүү. Тэгээд бид хэдий хийсэн юм бол яах вэ ингээд ийм л юм хийсэн юм.

Тэр дээд шатны Засаг даргыг бас сая Ж.Батсуурь гишүүн хэлээд байна. Дээд шатны Засаг дарга бол Ерөнхий сайдтай зэрэгцээд бас оруулдаг нь буруу гэсэн нэг хэсэг хүмүүс байна.

Тэр Ерөнхий сайд нь аймаг, нийслэлийн Засаг дарга дээрээ нэр дэвшүүлэх ажиллагаанд нь ингээд зэрэгцээд явж болдог юм гэхэд сүм, дүүрэг, баг, хороон дээр ингэмээргүй байна гэдэг ийм юм ярьж байгаа юмнууд байгаа.

Тэгээд энэ бол би зүгээр хүчлэх асуудал биш. Нэг ийм бодлогын л асуудал явсан юм. Тэгээд гишүүд өөрсдөө бодож тунгаах. Зүгээр дэгийн асуудал Л.Энх-Амгалан дарга өөрөө мэдэж байгаа шүү дээ. Сая наад дэгээр чинь анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн асуудлаар зайлшгүй шаардлагатай гэж үзээд гуравны хоёроор өөрчлөөд ингээд явчих бололцоо нь дэгээрээ байж байгаа.

Тэгээд хуралдаан даргалагч.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Ц.Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа.

Энэ ийм юм болчоод байгаа юм. Гишүүдээ. Шинээр оруулж байгаа бидний юм бол энэ дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд шаардлага хангасан хүнийг тухайн хуралд санал болгож болно гэж байгаа юм. Санал болгоно. Нэр дэвшүүлэх биш. Нэр дэвшүүлэх эрх нь хуралдаа байдгаараа байгаа байхгүй юу.

Тэгэхлээр тэр утгаараа Ж.Батсуурь гишүүн ээ, би энэ одоогийн байгаа практик нэг их айхтар зөрчигдөхгүйгээр явчихна гэж бодож байна.

Энд одоо бидний яваад ирсэн энэ ер нь зөв буруу, наанатай цаанатай ч гэсэн тогтчихсон явж байгаа практикийг жинхэнэ утгаар нь өөрчилж байгаа юм бол энэ хуулийг зааснаар томилохоос татгалзсан тохиолдолд Хурал өөр хүний нэрийг дэвшүүлнэ гээд бид тулгачхаж байгаа юм. Харин би үүнийг хасах саналтай байгаа юм.

Яагаад гэвэл энэ чинь нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байхад Их Хурлын дарга үүнийг засах чиг өгсөн шүү дээ.

Өөр хүний нэр дэвшүүлэхийг үүрэг болгож байгаа юм. Тэгэхгүй бол байна шүү дээ ийм болчоод байгаа байхгүй юу. Нэг удаа Хурал хуралдаж хуралдаж өөрийнхөө хүнийг дэвшүүлдэг. Тэрийг нь дээд шатны Засаг

дарга нь томилоогүй бол дараагийн хүнийг нь дээд шатны Засаг дарга нь заавал томилох ёстай болчоод байгаа байхгүй юу. Заавал томилох ёстай болчоод байгаа юм.

Тэгэхлээр нэг талаасаа дээд шатны Засаг дарга нь хурлын эрхэд дэндуу халддаг. Нөгөө талаасаа өөрөө тэр хүнийгээ томилох эрх нь бас хязгаарлагдчихаад байгаа байхгүй юу. Яагаад гэвэл хоёр дахь оруулж ирж байгаа хүнээ заавал томилох ёстай болчоод байгаа байхгүй юу.

Тэгэхлээр би ийм саналтай байна. Их Хурлын даргын өгсөн чигийн дагуу 56.7-г хасаад дээд шатны Засаг дарга, эсвэл Ерөнхий сайд тухайн нэр дэвшигчийг. Биш ээ. 8-ыг хасаад өөр хүнийг нэр дэвшүүлнэ гэдгээ хасчихмаар байгаа юм.

Тэгэх юм бол дээд шатны Засаг дарга нь хүний нэр санал болгоно. Тэрийг дэвшүүлэх үү, үгүй юу гэдгээ хурал өөрөө мэднэ. Дээд шатны Засаг даргадаа өгнө. Засаг дарга нь томилохгүй байж болно. Үндэслэлээ тайлбарлана. Тэгвэл хурал энэ хүн явахгүй юм байна. Энэ хүнийг дахиад дэвшүүлэх үү, өөр хүн дэвшүүлэх үү гэдгээ хурал өөрөө ахиад шийднэ. Өөрөөр хэлбэл Хурлын бүрэн эрхэд бид халдахгүй байгаа байхгүй юу.

Тэгээд дараа тэр хүн нь дахиад ороод ирэх юм уу, өөр хүн ороод ирэх юм бол дээд шатны Засаг дарга нь томилолтоо хийгээд явахад энэ бол одоо байгаа тогтолцооноосоо гажихгүй. Энэ нутгийн удирдлагын системийг бүрнээр нь орвонгоор нь эвдэхгүй ийм хувилбар болох гээд байна. Миний санал ийм байна. Дарга аа.

### **Л.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн.**

**Н.Энхболд:** Энэ томьёолол орж ирсэн нь бас зүгээр ганцхан аль нэг газраас шахаас гэж би ойлгохгүй байна. Сая Ж.Сүхбаатар гишүүн тийм юм хэлэх шиг боллоо. Бүлэг дээр надад лав тийм юм хэлсэн хүн байхгүй, нөлөөлсөн юм байхгүй.

Би жишээ нь дотроо юу гэж бодож энэ байр суурийг дэмжсэн бэ гэхээр нэгдүгээрт бид хамгийн түрүүнд бодож байх ёстай юм энэ Монгол Улс төрийн байгуулалтынхаа хувьд нэгдмэл байна гэдэг энэ том сууриа бүх юмныхаа суурь болгож бодож байх ёстай гэж би олон дахиж хэлж ярьдаг. Нэгд.

Энэ нь алдагдаж эхэлсэн. Ялангуяа гүйцэтгэх засаглалын талын юмнууд дээр бид сүүлийн 30 жилийн дотор сумын хэмжээнд ч, аймгийн хэмжээнд ч, төр засгийн төв Засгийн газрын бодлого хэрэгждэггүй, эсэргүүцдэг, биелүүлдэггүй.

Тэгээд зөвхөн орон нутаг бүх юм шийднэ. Хөрөнгөтэй мөнгөтэй аймгууд бараг олж байгаа юм, ганцхан бид шийдэж байх ёстай гэдэг маягаараа. Томоохон аж ахуйн нэгж, орон нутгийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулчхаад түүгээрээ нэлээд их дураараа загнах хүртэл гарч эхэлсэн шүү дээ.

Тэгээд энэ олон талаас нь бодсон. Нэг ийм талтай. Тэгээд ер нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол зарчим бол гүйцэтгэх засаглалынхаа хариуцлага, эрх, үүргийг тодорхой болгоё. Нэмэгдүүлье. Тийм ээ. Ийм суурин дээр бид юмаа хийсэн. Үүнийг их бодолцсон.

Нөгөө талаас нь лав д бид бүлэг дээр ярихдаа, бас Байнгын хороон ярихдаа ярьж байсан юм бол энэ манай улс төрийн соёлтой их холбоотой байгаа.

Ойрхон гарсан газрууд хуйвалддаг. Хаана ч байгаа шүү дээ. Суманд, аймаг дээр. Олонх болчихсон мөртлөө хуйвалдаад нөгөө талдаа хурлаа алдчихсан, засгаа алдчихсан ийм газрууд. Энэ удаагийн сонгуулиар ч байж байгаа. Орон нутгийн.

Энэ өөрөө угаасаа манай улс төрийг утгагүй болгож байгаа байхгүй ю. Бодлого гэж юм байгаа бол, нам гэж юм байгаа бол, намаар дамжиж энэ юмнууд нь хэрэгжих ёстой байх байтал сонгогдчихсон хойноо янз бүрийн шалтгаанаар мөнгө авна уу, албан тушаал амлуулна уу.

Тэгээд сонгуулийнхаас шал эсрэг дүн гарчхаад байгаа юмнууд байж байгаа. Энэ өөрөө манай улс төрийн соёлтой бас холбоотой. Энэ талаас нь ч бид бодсон юм.

Тэгээд ярьж ярьж байгаад жишээ нь миний дэмжсэн хувилбар нь гэхээр ямар ч байсан Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн агуулга. Монгол Улс угаасаа төрийн байгуулалтын хувьд нэгдмэл байх ёстой гэдэг зарчим.

Тэгээд ерөөсөө хариуцлагыг хэн нь хүлээх нь мэдэгдэхгүй алга болдог ийм зүйл байгааг гүйцэтгэх засаглалаа жаахан бэхжүүлье гэсэн энэ гол шугам дээр бид ярьж байгаад Ерөнхий сайд юм уу, дээд шатны Засаг дарга нь бас санал оруулах эрхтэй байна. Ядаж.

Жишээ нь, урваж шарваад ингээд юу яачихсан юм. Та нар нэг бodoод үз л дээ. Энэ чинь нэг нам ялчхаад мөрийн хөтөлбөр нь хэрэгжих гээд явж байхад ийм болчихсон байна шүү дээ гэж анхааруулга дохио болох үүднээсээ ч гэсэн ядаж. Наад хүнийг чинь би зөвшөөрөхгүй ээ. За яах вэ одоо үндэслэл байвал байна байх. Гэхдээ сая миний хэлсэн зүйлүүд бол нэг том үндэслэл болдог.

Ийм ийм зүйлүүдээсээ болоод бид санал болгож болно. Эцсийн шийд нь хурал нь гаргана. Дэвшигүүлээд ирвэл заавал хоёр дахь удаагаа бол томилохоос өөр аргагүй болно. Дахиад л нөгөө яг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн маань зарчим бас буурч л байгаа байхгүй ю. Хэрэгжихгүй л тал руугаа, хагас тал руугаа л орж байгаа.

Анхнаасаа ерөөсөө дээрээсээ томилдог байя гэсэн ийм л агуулгатай хууль орж ирсэн шүү дээ. Тийм ээ. Засаг дарга нарыг ингээд шууд Ерөнхий

сайд аймаг нийслэлээ. Аймаг, нийслэл нь доошоо ингээд томилоод явдаг байя гэж.

Тэгээд тэр үнэхээр бас л манай энэ одоогийн нөхцөл байдал, улс төрийн соёл, бодитой байдал энэ юмнуудаасаа болоод тэр явж чадаагүй. Тэгээд орж ирсэн өөрчлөлтдөө тааруулаад хийсэн арай зөвлөн хувилбар нь энэ юм болов уу л гэж бид бодож жишээ нь үүнийг оруулсан юм.

Одоо нээрээ ярих юм байгаа бол миний хэлсэн юмнуудтай Ж.Батсуурь гишүүн бол санал нийлэх байх гэж бодож байна. Зарим юм нь дээр. Одоо ярих юм байгаа бол.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Би Н.Энхболд гишүүний хэлж байгаа саналыг хүндэтгэж хүлээж авч байна.

Ер нь тайлбар тийм л явсан. Зүгээр яах вэ, бид сая Г.Занданшатар дарга харин нөгөө ажлын хэсэг яагаад ийм дураараа нэг ийм юм хийчхэв гээд.

Тэр нь Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн гаргасан шийдвэрийг ажлын хэсэг л томъёолсон хэрэг шүү дээ гэдгийг л би хэлэх гэсэн юм. Түүнээс дураараа хийсэн биш гэдэг утгаар. Түүнээс тулгах ч юу байх вэ. Тэгээд би өөрөө ч бүлгийн дэд дарга хүн. Тэрийг нь ингээд дэмжээд ингээд томъёолсон.

Үндсэн хуулийн хувьд нэг их зөрчигдсөн гэж үзэхгүй байгаа. Ер нь Үндсэн хуулийн гол агуулга бол Хурал нэр дэвшигүүлэгч, Засаг дарга томилогч гэсэн. Дээд шатных нь нь томилогч гэж.

Тэгэхээр одоогийн энэ өөр хүн яагаад ороод ирсэн юм бэ гэхээр зэрэг үндсэндээ бид чинь Үндсэн хуульд “томилно” гэсэн үгийг нь болохоор “батламжилна” гээд ингээд бүр яриад сурчихсан байгаа байхгүй юу. Тэрэндээ нийцүүлээд ийм болгочихсон. Цэцийн шийдвэр гараад.

Одоо энэ өөр хүний нэр чинь орохгүй болохоор зүгээр л тэр хүнийг оруулсан нэг хүнээ зүтгүүлээд хоёр дахь удаад нь зүгээр л дээд талынхаа томилогч этгээдийг үл хэрэгсээд явчхаж байгаа юм. Үгүй ээ, би энэ нөхөртэй чинь ажиллахгүй шүү гээд хэлчхээд байхад хоёр дахь удаа нь дахиж оруулаад үгүй үгүй чи томил гээд. Тэгээд яалт ч үгүй томилчхож байгаа юм.

Энэ чинь бүр нөгөө томилж байгаа хүн биш, нөгөө хүн чинь бүр хүчинд. Өөр хүний нэр гэхээр чинь олон кэйс байгаа юм л даа. Энэ чинь олон тохиолдол.

Гэхдээ би нөгөө талаас нь үүнийг харна. Нөгөө томилох гэж байгаа хүн чинь үгүй ээ, үгүй би яг энэ Д.Тогтохсүрэнтэй энэ аймгийн даргаар нь ажиллуулахгүй ээ гэж байхад, за за тэгвэл Д.Тогтохсүрэн нь болчихвол өөр

хүн орж ирж байна. Тэрийг нь яах вэ томилогч тал нь яах аргагүй хурлынхаа шийдвэрийг хоёр дахь удаад нь зөвшөөрч байгаа юм.

Гэхдээ дараагийн жил нь тэр хүнд үнэлэлт дүгнэлт өгч огцруулах эрх нь бас үлдэж байгаа байхгүй юу. Томилох эрхийг нь. Хэрвээ өөр хүн нэр дэвшүүлэх эрхгүй болчиноор анхнаасаа чи тэртээ тэргүй хуралтай хуралгүй хурлын шийдвэрийг чи биелүүлэхгүй байхаас аргагүй. Чи томилно гээд тулгачхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр чи ингээд. Одоо бид чинь Улсын ерөнхий прокурорыг, жишээлбэл Их Хурлын практик дээр зөвшилцэнэ гэдэг дээр Улсын Их Хурал дэмжээгүй хүнийг чинь дахиж оруулж ирдэггүй байхгүй юу. Энэ чинь учиртай шүү дээ.

Тэр хүний бодлогыг нь. Томилогч этгээд чинь томилгооны бодлогыг хадгалж байгаа хүн байхгүй юу. Тэр хүнтэй ажиллахгүй, чи энийг гэхэд тэр хүнийг нь угаасаа зөвшөөрөхгүй гэж байгаа хүнийг чинь тулгана гэдэг чинь. Одоогийн практик бол тулгалтаар яваад байгаа байхгүй юу. Хурлын тулгалтаар.

Тэгэхээр чинь үүнийг л өөр хүн гэж хийж байгаа. Бараг тэгвэл тэр эхний шатанд нь санал болгох эрхээсээ татгалзаад энэ өөр хүнээ авч үлдэх нь томилогч этгээдэд хэрэгтэй байхгүй юу. Бараг үндсэндээ бол.

Тэгэхээр ийм юмнууд яваад байгаа юм. Тэгээд үүнийг зүгээр яах вэ бодно биз. Тэгэхгүй бол татгалзаж байгаагийн учир нь тэр шүү дээ. Тэр хүнийг өөр хүн оруулж ир л гэсэн учир.

Зүгээр тэр хоёр дахь орж ирсэн хүнийг татгалзах эрхгүй байгаа нь л хүнд асуудал болж байгаа ч гэсэн энэ чинь нөгөө огтлолцож байгаа учраас л Хурал, Засаг дарга хоёр харилцан буулт хийх, Хурлын давуу эрх чинь тэр тохиолдолд гараад ирж байгаа юм л даа. Бас тэгэхээр Хурлынхаа давуу эрхийг хангаж өгч байгаа байхгүй юу.

Тэгэхгүй өөр хүн оруулахгүй болохоор Хурлын давуу эрх тэр чигтээ яваад л дуусчихна. Зүгээр л тэр хүн ёсчилно. Тийм л механизм ард нь үлдчихээд байгаа юм. Тэрийг л бас бodoх хэрэгтэй л дээ.

Бид мугуйдлах юм байхгүй шүү дээ. Ажлын хэсэг томьёолол нь хамгийн байж болох бодлогынх нь цаана нь ийм л гэж тайлбарлаад байгаа юм. Тэрнээс энэ бол бараг улс төрийн бодлогын л асуудал л даа. Ер нь бол. Удирдлагын.

**Л.Энх-Амгалан:** Ингэе. Гишүүд ээ. Дэгээрээ явъя. Тэгэх үү. Дэгээрээ явъя.

Одоо ингээд эцсийн хэлэлцүүлэг хийж байгаа учраас гурван тохиолдол байгаа юм.

Нэгд нь, гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

Хоёрт нь, анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь өөр хоорондоо, эсвэл бусад хуулиудтай зөрчилдсөн тохиолдолд дахин хэлэлцүүлэг хийнэ.

Гуравт нь, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг асуудлаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гээд ийм гурван тохиолдол байгаа байхгүй юу.

Тэгэхээр сая Ж.Батсуурь гишүүний гаргасан дөрвөн зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хоёр нь угаасаа анхны хэлэлцүүлэг дээр ерөөсөө хэлэлцэгдээгүй, яригдаагүй учраас энэ хоёрыг бид санал хураалгах үндэслэлгүй.

Хоёр нь, анхны хэлэлцүүлэг дээр яригдсан, дэмжигдсэн асуудал юм байна. Одоо ингээд саяын тайлбар хэлээд байгаа.

Тэгэхээр Ж.Батсуурь гишүүний гаргасан энэ хоёр зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал хураагаад дэмжих үү, хэлэлцэх үү, хэлэлцэхгүй юу гэдэг томьёоллоор санал байгаад тэгээд шийдчихье. Тэгэх үү? За тэгье.

Санал хураалт. Сая хэлчихсэн шүү дээ. Тийм. Гуравны хоёроор хэлэлцэх үү, үгүй юу.

12 гишүүн оролцож, 12 гишүүн зөвшөөрсөнгүй.

Ингээд зөвшөөрөөгүй учраас энэ хоёр саналын томьёоллоор санал хураалт хийхгүй гэсэн үг.

Ингээд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулна. Ажлын хэсгийн ахлагч.

Одоо дараагийн асуудалд орно.